

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН
ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг баримтлан Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа явууллаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгож буй үндэслэл болон буцаан олголтыг татварын системийг эвдэхгүйгээр нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтээр нь шийдвэрлэх боломжтой эсэх, мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн нь оновчтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сайжруулах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлэх нь далд эдийн засгийг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул татварын бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Нэмэгдсэн өртгийн албан татварын 5 хувийн буцаалтын хууль хэрэгжсэнээр татварын бааз суурь нэмэгдэх, далд эдийн засаг буурах, худалдааг дэмжихэд нөлөөлөх эсэх, мөн татварын буцаан олголтыг хувь хэмжээг нэмэгдүүлэхэд татвар суутган төлөгчийн тоо болон төсвийн орлого хэрхэн өөрчлөгдөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нийт өрхийн 30 гаруй хувь нь тэтгэвэр, тэтгэмж авагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил эрхэлдэггүй болон халамжаар амьдардаг иргэд байгааг дурдаж, эдийн засгийн хүндрэлтэй үед иргэдийн орлогыг дэмжих зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэх тооцоолол хийсэн эсэх, Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгох нь оновчтой эсэх, мөн өрхийн гишүүдийн тооноос хамааран татварын бодлогоор дэмжих боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн

Г.Ганбаатар Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу олгох нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын дүн болон төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн бүтцийн өөрчлөлтийг хийх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 51.3 хувь буюу олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

